

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Хичээлийн жил эхлээд хоёр долоо хоног өнгөрч хэдийгээр зуны амралт мартагдаж эхэлж байгаа ч Дунд Сургуулийн сурагчид маань Бүүвэйт, Тэнгэрийн Элч, Хустайд гурван өдрийн кемп аялал хийж Бага Сургуулийн сурагчид маань уламжлалт пикникээ энэ Баасан гарагт хийлээ.

Энэ хоёр арга хэмжээнд оролцсоноор сурагчид маань цагийг хөгжилтэй өнгөрүүлж, бие биентэйгээ дотно танилцаж, багаар ажиллах ур чадвараа дээшлүүлж, шинэ шинэ сорилтуудыг даван туулах боломжтой байдаг. Багш нар маань ч энэ үеэр сурагчдаа сайтар танин мэдэж тэдэнтэй дотно эерэг харилцаа холбоог бий болгож чаддаг бөгөөд зарим сурагчдын хувьд энэ арга хэмжээнүүд нь сурлагандаа амжилт гаргах гол үндсэн хөшүүрэг болдог.

Ирэх долоо хоногт дугуйлангууд хичээллэж эхэлнэ. Сурагчиддаа зориулж олон төрлийн дугуйлангууд ажиллуулах гэж байгаадаа бид баяртай байна. Өнгөрсөн долоо хоногийн сүүлчээр дугуйлангийн талаарх мэдээллийг та бүхэнд хүргэсэн.

Сургууль дээр болж байгаа энэ олон арга хэмжээнүүдийн хажуугаар эхнэр бид хоёр Монголын соёл, монгол орчинтой танилцаар байна. Өнгөрсөн долоо хоногт бид Тэрэлжид сургуулийнхаа багш ажилчидтай очиж анх удаагаа Хорхог идэж үзлээ. Цэлмэг хөх тэнгэр, сүрлэг өндөр уулс, цэнгэг устай голын эрэг дээр Хээрийн хоолыг амтархан идэж багш ажилчдынхаа уянгалуулан дуулахыг сонсоход их сайхан байлаа. Монголчууд дуу хуурт дуртай ард түмэн гэж би сонссон. Миний дуулсан “I Understand” дууг хэн нэг нь дуу хураагуурт бичээгүй гэж найдаж байна.

Удахгүй хүйтний улирал эхлэх тул намрын нар буцаагүй байгаа дээр ирэх амралтын өдрүүдэд агаарт гарахыг надад хүмүүс зөвлөсөн. Та бүхэн ч гэсэн энэ амралтын өдрүүдэд агаарт сайхан өнгөрүүлээрэй.

Захирал Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

9 сарын 6-ны Мягмар гараг	Дугуйлангууд хичээллэж эхэлнэ
9 сарын 8-ны Пүрэв гараг	Нээлттэй Хаалганы Өдөрлөг 18:30-20:30 ЗӨВХӨН ЭЦЭГ ЭХЧҮҮД ОРОЛЦОНО
9 сарын 13-ны Мягмар гараг	12-р ангийн сурагчдын эцэг эхэд коллежийн мэдээлэл өгөх уулзалт- 18:30-20:00 Номын Санд
9 сарын 15-ны Пүрэв гараг	Монгол, Солонгос эцэг эхчүүдэд ОУДС-ийн талаар мэдээлэл өгөх уулзалт 18:30
9 сарын 17-ны Бямба гараг	ОУДС-ийн Намрын Баяр 11:00-14:00
9 сарын 23-ны Баасан гараг	Фото Зургийн өдөр

Нээлттэй Хаалганы Өдөрлөг

9 сарын 8-ны Пүрэв гарагт 18:30-д болох Нээлттэй хаалганы өдөрлөгт та бүхэн хүрэлцэн ирээрэй. Энэ өдөрлөгийн үеэр эцэг эхчүүд та бүхэн хүүхдийнхээ багш нартай уулзаж хичээлийн хөтөлбөр болон ИВ байгууллагын гурван хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой. Багш нар эцэг эхчүүдэд нийтэд нь ерөнхий мэдээлэл өгнө. Энэ уулзалтын дараа ЭББ-хэн жил бүрийн уламжлал ёсоор бяслаг, дарсаар та бүхнийг дайлах болно.

Нээлттэй Хаалганы Өдөрлөгийн Хуваарь

Бага сургуулийн багш нартай та бүхэн дараах хуваарийн дагуу уулзаж болно. Анги удирдсан багш нартай уулзах цаг:

18:30-18:50

18:50-19:10

Мэргэжлийн багш нартай уулзах цаг:

18:50-19:10

19:10-19:30

18:30-19:30-д Дунд Сургуулийн багш нар коридорт тус тусын ширээний ард та бүхэнтэй уулзах болно.

19:30-д бүх эцэг эхчүүд сургуулийн заланд цугларна. Дараа нь ЭББ-ийн бяслаг дарсны дайллага болно.

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Хичээлийн шинэ жил амжилттай эхэлж ОУДС-д ирсэндээ баяртай байгаа шинэ багш сурагчдаа харахад сайхан байна. Бид үнэхээр сайн сургалттай сайхан хамт олон.

Жил бүр дунд сургуулийн багш сурагчид кемп аялалд явдаг бөгөөд энэ үеэр бид олон сонирхолтой арга хэмжээнүүд зохион байгуулж, явган аялал хийж, хоорондоо танилцаж дотно нөхөрлөдөг юм. Баасан гарагийн орой кемп аялалаас эргэж ирэхээр нь та бүхэн хүүхдүүдээсээ аялалын сонинг сонсоорой. Дараагийн Мэдээн дээр аялалын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлийг бид бичих болно.

9 сарын 8-ны орой болох Нээлттэй Хаалганы Өдөрлөгийн үеэр бид та бүхэнтэй уулзана гэж найдаж байна. Энэ үеэр та бүхэн хүүхдийнхээ багш нартай уулзаж энэ хичээлийн жилд хүүхдийнхээ судлах хөтөлбөрийн талаар мэдээлэл авах болно. Энэ арга хэмжээ Пүрэв гарагийн орой 18:30-д эхлэх тул та бүхэн энэ өдрийг хуанлидаа тэмдэглээрэй. Энэ үеэр та бүхэн бас манай шинэ захирал Mr. Robert Stearns-тэй уулзах боломжтой.

Зуны төгсгөл намрын эхэн сарын нарлаг дулаахан өдрүүдийг та бүхэн сайхан өнгөрүүлээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

ОУДС-д ирж ажиллаад удаагүй байгаа миний хувьд өнгөрсөн хоёр долоо хоногийн хугацаанд өглөө болгон биднийг найрсгаар угтан авч байгаа эцэг эхчүүд, сурагчдаа хараад би үнэхээр баяртай байна. Та бүхэнд баярлалаа.

Сурагчид маань хичээл сургуульдаа дасаж хичээлийн шинэ жилээ амжилттай эхэлж байна. Би та бүхэнтэй 9 сарын 8-ны орой Нээлтэй Хаалганы Өдөрлөгийн үеэр уулзана гэж найдаж байна. Би та бүхэнтэй бүгдтэй нь ойрын хугацаанд уулзана гэж найдаж байна.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya